

ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

2010.03.11

Сүхбаатар

Нэг.Монгол Улсын Шадар сайдад:

Стандартчилал, хэмжилзүйн үйл ажиллагааны чиглэлээр:

4 төрлийн бүтээгдэхүүнийг 68.3 сая төгрөгийн санхүүжилттэйгээр 97.2 хувийн гүйцэтгэлтэй нийлүүллээ.

Сорилтын лабораториуд 977 дээж, 1145 арчдасанд нян судлалын шинжилгээ, 680 хүнсний бүтээгдэхүүний дээжинд химийн шинжилгээ, 396 тарих үрийн дээжинд чанарын шинжилгээ нийт 3198 дээжинд 11796 хими, физик, нянгийн шинжилгээ хийсэн байна. Сорилт шинжилгээнээс 4434.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 118.2 хувиар биелүүллээ.

Үйлдвэрлэл нь тогтворжиж чанар, стандартын шаардлага хангасан 11 аж ахуйн нэгжийн 12 бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгож баталгаажуулав.

Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр: 1 ангийн 3 бүтээгдэхүүнийг 95 хувьтай нийлүүлж, Хүүхэд хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн 3 дахь шатны үйл ажиллагаа 93.5 хувьтай хэрэгжлээ. “Гэр бүл-хүүхдийн ордон”-д хүүхэд багачуудын авъяас билгийг нээн хөгжүүлэх зорилгоор 18 төрлийн дугуйлан хичээллүүлж улс, аймгийн тэмцээнээс 77 алт, 63 мөнгө, 69 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүллээ. Хүүхэд өсвөр үеийнхнийг тодорхой зорилго тэмүүлэлтэй амьдрах хүмүүжилтэй болгох эрүүл амьдралын зөв дадлыг хэвшүүлэх, үр хүүхдийнхээ төлөө эцэг эх, иргэний хүлээх хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор “Ирээдүйгээ зөв төлөвшүүлэе” аяныг аймгийн хэмжээнд өрнүүлэн “Хүүхэд бүхэн жаргалтай байг”, “Хүүхэд гэр бүл”, “Хөгжицгөө”, “Гэмт хэрэг зөрчилгүй хамт олон болох” зэрэг томоохон арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

Хоёр.Батлан хамгаалахын сайдад:

4 бүтээгдэхүүн ангийн 16 нэр төрлийн 15-ыг 100 хувь, 1-ийг 94.5 хувьтай нийлүүллээ.

Дайчилгааны бэлтгэл нөөцийн 1 дүгээр зэргийн чухал мэргэжлийн бэлтгэл үүрэгтэн цэрэг, түрүүч 60 хүнтэй явуулах сургалт, цэрэгт тэнцэгчдийг аймгаас алба хаах анги хүргэх зардал, дүйцүүлэх албыг биеээр хааж байгаа иргэдийн сургалтын зардал болон гэрээнд заасан бусад арга хэмжээний зардлыг улс, орон нутгийн төсвөөс цаг хугацаанд нь бүрэн санхүүжүүлсэн.

Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнтэй сургалт явуулахдаа Батлан хамгаалах туслах нийгэмлэгийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлийн хичээлийн 2 танхим, Хилийн цэргийн 0243 дугаар ангийн Сургалтын төвийг ашиглаж байгаа бөгөөд сургалтын орчин, нөхцөлийг сайжруулахад анхаарч ажиллалаа.

Гурав.Хууль зүй, дотоод хэргийн сайдад:

Хууль зүй, дотоод хэргийн сайдад байгуулсан гэрээний дагуу Удирдлага зохион байгуулалтын 5, Гэмт хэрэгтэй тэмцэх 6, Нийгмийн хэв журам сахиулах 5, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 10, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх 2, нийт 5 ангийн 5 тусгай захиалгат, 33 бусад нэр төрлийн бүтээгдэхүүн нийлүүлж 1.423.711.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас, өөрийн орлогоор 7.2 сая төгрөг оруулах, төсвийн санхүүжилтээр 1.423.711.2 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төсөвлөгдсөн бөгөөд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийн зарцуулалтын тайлан мэдээг сар, улирлаар гарган тайлагнаж ажилласан.

Удирдлага зохион байгуулалтын талаарх 5 бүтээгдэхүүний биелэлт 90.0 хувь, гэмт хэрэгтэй тэмцэх 6 бүтээгдэхүүний биелэлт 90.0 хувь, нийгмийн хэв журмын 5 бүтээгдэхүүний биелэлт 90.0 хувь, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 10 бүтээгдэхүүний биелэлт 90.0 хувь, тусгай захиалгат 4 бүтээгдэхүүний биелэлт 90.0 хувь, өмчлөгчийн эрхийг шилжүүлэх 2 бүтээгдэхүүний нийлүүлэлт 100.0 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг 2008 оныхоос 15.3 хувиар буурсан.

Бүртгэгдэх үедээ эзэн холбогдогч нь тогтоогдоогүй байсан гэмт хэргийн илрүүлэлт 63.4 хувьд хүрч, хэргийн илрүүлэлт өмнөх оныхоос 26.3 хувиар өссөн.

Гэмт хэргийн улмаас улс, иргэдэд учирсан хохирлын 66.9 хувийг нөхөн төлүүлсэн. Өнгөрсөн онд тооны хувьд өссөн хүчиндэх, дээрэмдэх, залилан мэхлэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргүүд 15.2–3.6 дахин буурсан.

Хулгайлах болон мал хулгайлах гэмт хэргүүд сүүлийн 2 жилд дараалан буурсан. Түдгэлзүүлсэн хэргийн тоо буурч, түдгэлзүүлсэн хэргийн илрүүлэлт шийдвэрлэлт дээшилсэн. Хүнд, онц хүнд гэмт хэргийг 100 хувь илрүүлсэн.

Дөрөв.Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдад: 8 бүлэг бүтээгдэхүүнийг 96.9 хувь нийлүүлж, салбарын төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд 12.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг цаг хугацаанд нь бүрэн олголоо. 2009 онд бага боловсролыг 946, суурь боловсролыг 1807, бүрэн дунд боловсролыг 1651 суралцагч эзэмшлээ. Аймгийн хэмжээгээр ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт нийт 1136 багш ажиллаж байгаа бөгөөд нийт багшийн 48.6 хувь нь мэргэжлийн зэрэгтэй байна.

Суурь боловсролын хамран сургалт 98.4 хувьд хүрч, өмнөх оныхоос 0.2 хувиар ахисан байна. Аймгийн хэмжээнд 19 дотуур байранд 1421 хүүхэд амьдарч, дотуур байрны хамралт 93.1 хувьтай байна. Үүнийг өмнөх оныхтой харьцуулахад 3.3 хувиар ахисан үзүүлэлттэй байна.

Боловсролын салбарт 2009 онд 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ.

Тав.Эрүүл мэндийн сайдад: 11 бүлэг бүтээгдэхүүнийг 86.7 хувь нийлүүлж, эрүүл мэндийн 37 нэгж байгууллагуудад 5.5 тэрбум төгрөгний санхүүжилтийг цаг хугацаанд нь бүрэн олголоо.

2009 онд 1848 эх төрж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1000 хүн ам тутамд төрөлт 1.6-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Товлолтот дархлаажуулалтанд хүүхдийг бүрэн хамруулснаар тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний өвчлөл бүртгэгдээгүй. Стационарт 21800 өвчтөн эмчлэгдэн гарч, 176506 ор хоног ашигласан байна.

Халдварт шар өвчин 10000 хүн амд 11.4 ногдож, өнгөрсөн оны мөн үеэс 20.9 хувиар буурсан байна. Аймгийн хэмжээнд өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 26 удаа сургалт зохион байгуулж, 43560 хүнийг хамрууллаа. Томуугийн А хүрээний H1N1хүрээний вирусын халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх ажилд 25,6 сая төгрөгийг зарцууллаа.

Аймгийн хэмжээнд спортын 17 клуб, холбоод ажиллаж, аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 18 удаа, нэрэмжит тэмцээнийг 8 удаа, нийтийн биеийн тамирын арга хэмжээг 45 удаа зохион байгуулж, аймгийн нийт хүн

амын 25.9 хувийг хамруулж, 26570 гаруй иргэд оролцлоо. Аймгийн хэмжээнд спортын чиглэлээр 164 секц, дугуйланд 2560 гаруй тамирчид хичээллэж, улсын аварга шалгаруулах тэмцээнд 1020 тамирчин оролцож, 97 медаль хүртсэн байна. Эрүүл мэнд, спортын салбарт улсын болон орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөрийн шугамаар 1 тэрбум 767.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ.

Зургаа.Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдад: Ерөнхий 6 анги, тусгай захиалгат бүтээгдэхүүн 2 анги нийт 8 анги бүтээгдэхүүнийг 90.4 хувь нийлүүлж, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн хамгааллын чиглэлээр 24.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хугацаанд нь бүрэн олголоо.

Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх үйлчилгээний хүрээнд 45340.1 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж нийгмийн даатгалын санд 9056.2 сая төгрөгийн шимтгэлийг татан төвлөрүүллээ.

Аймгийн бүртгэлийн газартай хамтран бичиг баримтгүй хаягийн бүртгэлгүй 184 иргэнийг хаягийн бүртгэлтэй болгож, бичиг баримтжуулж ажиллалаа. Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1131 хүнийг хамруулж 195532.1 мянган төгрөг, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж авах шаардлагатай 1275 иргэнд 151658.4 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж хөнгөлөлтөнд 397 иргэнийг хамруулж, 49216.1 мянган төгрөг, 1940 ахмад настанд 48032.3 мянган төгрөг, ахмад дайчин 48 хүн 109648.0 мянган төгрөгийн хөнгөлөлт үйлчилгээнд тус тус хамрагдлаа.

Аймгийн хэмжээгээр 2009 онд 2222 шинэ ажлын байр бий болж төлөвлөгөөний биелэлт 111 хувьтай байна. Хөдөлмөр эрхлэлийг дэмжих сангаас 71 удаа 1403 ажилгүй иргэдийг нийтийг хамарсан ажилд хамруулж, 114265.6 мянган төгрөгийг зарцууллаа. Мөн 37 иргэнд 40675.6 мянган төгрөгийн жижиг зээл олгож, 45 шинэ ажлын байр бий болголоо.

Мэргэжил олгох давтан сургалтанд 527 иргэнийг 14 төрлийн сургалтанд хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 59614.5 мянган төгрөгийг зарцууллаа.

Үүнээс байнгын ажлын байранд 347 хүн зуучлагдлаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 30 аж ахуй нэгж, байгууллагад 45505.9 мянган төгрөгийн урамшуулал олголоо.

Орон нутгийн ахмадын байгууллагыг дэмжих үйлчилгээний хүрээнд 8838.0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж, 100 хувиар биелсэн байна.

Мөн ажиллаж байсан байгууллага нь татан буугдсан, дампуурсан, шилжиж ирсний улмаас харъяалалгүй болсон ахмадуудыг харъяалалтай болгох ажлыг зохион байгуулан 1500 ахмад настанд сар шинийн хүндэтгэл үзүүллээ.

Долоо.Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад: 4 ангийн 4 бүтээгдэхүүнийг 92.0 хувьтай биелүүлж ажиллалаа. Баянгол, Мандал, Сүхбаатар сумдын цаг уурын станцад интернет холболт хийж, томоохон голуудын усны ай савын харуул газруудад Азийн хөгжлийн сангийн төслийн шугамаар орон нутагтаа голын усны биологийн дээжийг тодорхойлж, багаж тоног төхөөрөмжөөр хангах, Баруунхараа дэд станцыг түшиглэн цаг уурын сургалтын төв байгуулан ажиллаж байна.

2009 онд цаг уурын 3 станцыг унаагаар /мотоцикол/ -аар хангаж, 3 сумын төвд цаг уурын урьдчилсан мэдээллийн самбар байршуулан цаг агаарын төлөв, байдлыг иргэдэд цаг алдалгүй шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж байна.

Цаг уурийн өөрчлөлтийг 7 хоног, 1 сар, улирлын урьдчилсан төлөвийг сум, бүс нутаг тус бүрээргарган малчид, тариаланчдыг мэдээллээр хангах боломжийг бүрдүүллээ.

“Нэг уурхай-нэг булаг” тохижуулах аяны хүрээнд тус аймагт ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа ус ашиглагч байгууллагууд өөрийн хөрөнгөөр Ерөө, Баянгол, Хүдэр, Түшиг сумдад нийт 13 булаг усны эхийг тохижуулж, улсын төсвийн хөрөнгөөр Сайрын, Цагаан давааны, Ар могойн аршаан, Төсгөө, Номт, Нянгай, Туурийн зэрэг 7 булаг усны эхийг хашиж хамгаалалтанд авлаа.

Найм.Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдад:

4 төрлийн бүтээгдэхүүнийг 38 арга хэмжээг 97.0 хувийн биелэлт нийлүүллээ. Үүнээс томоохон ажил арга хэжээнээс онцолвол: Мандал сумын 38, Сүхбаатар сумын 20 айлын орон сууцуудыг шинээр барьж ашиглалтанд оруулж, улсын төсвийн 180.2 сая төгрөгийн хөрөнгөөр аймгийн төвийн 5 давхар угсармал 15-20-р байрнуудын

дээврийг сэргээн засварлаж, улсын төсвийн 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хушаат сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг шинээр барьж ашиглалтанд орууллаа.

Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18-р зүйлыг хэрэгжүүлэх зорилгоор 3 сумын сууц өмчлөгчийн холбоодын судалгааг нэгтгэж эхний ээлжинд мэдээллийн сан бүрдүүлээд байна. Аймгийн хэмжээний барилга байгууламжийн тоог гаргаж хувийн хэрэгтэй болгох ажлыг зохион байгуулж байна.

Мөн Аймгийн хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын хэмжээ, зориулалт, байршлын талаархи саналыг сумдаас авч аймгийн ИТХТ-ээр хэлэлцүүлэн 2009 онд 4716.9 га газрыг өмчлүүлэхээр батлуулж, 551 иргэнд 95.6 га газрыг өмчлүүллээ.

Кадастрын зураглал ба газрын бүртгэл төсөлтэй хамтран хэрэгжүүлж байгаа “Үндэсний газрын мэдээллийн систем”-ийг ажиллуулахаар Газрын харилцаа, геодези зураг зүйн газар, “Цахилгаан холбоо” ХХК, үүрэн холбооны “Жи-мобайл” ХХК-тай хамтран 17 сумын газрын даамлыг интернэт үйлчилгээнд холбох гэрээ байгуулан ажиллаж байна. Сүхбаатар сумыг “Миком” ХХК-ны ADSL /512kb/ модемоор, Цагааннуур, Зүүнбүрэн, Баянгол, Хушаат сумдыг Жи-мобайл ХХК-ны 64 kb-н хурдтай модемоор холболоо.

Ес.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад: 16 стратегийн зорилтын 40 арга хэмжээ төлөвлөгдөж 95.8 хувьтай биелүүлж ажиллаа.

Кадастрын зурагт ороогүй аймгийн хэмжээний тариалангийн талбайн тооллогонд нийт 7633 нэгж талбарын 319453.12 га талбай хамрагдснаас 4081 нэгж талбарын 309325.0 га-г үр тарианы зориулалтаар, 3502 нэгж талбарын 6944.49 га-г төмс, хүнсний ногооны зориулалтаар ашиглагдахаар, 50 нэгж талбарын 3144.38 га нь атаршсан газрын ангилалд тоологдоод байна.

Тайлант онд 190 нэгж талбарын 2139 га үр тарианы талбай, 39 нэгж талбарын 70.5 га төмс, хүнсний ногооны талбайд хэмжилт хийж нэгдсэн зураглалд орууллаа.

Усалгаатай тариалан эрхэлж байгаа болон шинээр усалгаатай тариалан эрхлэх талбайн хайгуулын ажлыг зохион байгуулж, 2009 онд 4008 га буудай, 160 га-д арвай, овъёос 5 га, гурвалжин будаа 3 га, тэжээлийн ургамал 50 га, бусад 60 га, рапс 300 га бүгд 4586 га-д усалгаатай тариалалт явуулсан нь зохих үр дүнгээ өгсөн.

Малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх, үржлийн ажил үйлчилгээний хүртээмж үр дүнг сайжруулан сүргийн бүтцийг сайжруулахаар 8 суманд мах, сүүний үхрийн гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх цэгийг ажиллуулж, нийт 855 хонь, 1077 үнээнд зохиомол хээлтүүлэг хийсэн.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙН НЭГТГЭЛ**

2010.03.11

№	Салбарын нэр	Бүтээгдэхүүний тоо	Нийт хувь
1	Монгол Улсын Шадар сайд	7	96,1
2	Батлан хамгаалахын сайд	16	99,6
3	Хууль зүй, дотоод хэргийн сайд	6	91,6
4	Боловсрол соёл, шинжлэх ухааны сайд	8	96,9
5	Эрүүл мэндийн сайд	11	86,7
6	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд	8	90,4
7	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	4	92
8	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд	4	97
9	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	16	95,8
НИЙТ			94.0

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

